



ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

<b>НЭГ. БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВАХ</b>	
<b>Баримт бичгийн нэр</b>	<b>Тайлбар</b>
1.1. Захиалагчийн хүсэлт	Захиалагчийн өргөдөл, албан бичиг /иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
1.2. Газар олгосон тухай шийдвэр, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр	- Газрын захирамж, гэрчилгээний хуулбар; - Дулаан хангамж, Цэвэр бохир ус, Цахилгаан хангамж, Холбоо радио хангамж зэрэг хангагч байгууллагуудаас авсан техникийн нөхцөлийн хуулбар;
1.3. а) Магадлал хийгдсэн иж бүрэн ажлын зураг төсөл, магадлалын дүгнэлт, төсөв б) Барилгын тэг тэнхлэгийг газарт шилжүүлсэн акт	а) Зураг төсөлд магадлал хийх эрх бүхий байгууллагаар хийлгэсэн ажлын зураг, магадлалын дүгнэлт хавсралтын хамт, барилгын ажлын төсөв; б) Геодезийн эрх бүхий зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэсэн байх;
1.4. Зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	Зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
1.5. Байгаль орчны хууль тогтоомжийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн үнэлгээний тайлан	“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7.4. “Шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч ажлын 14 хоногт багтаан хийж дараах дүгнэлт гаргана.” гэж заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний тайлан;
1.6. Гэнэтийн ослийн болон хариуцлагын даатгалд даатгуулсан бол гэрчилгээг хавсаргах	Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Барилгын тухай хуулийн 8.3-т “Энэ хуулийн 44.3.2, 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.” гэж заасны дагуу мөн хуулийн 44.3.2, 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна. Мөн хуулийн 8.4. Барилгын ажлын гүйцэтгэгч тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна;
1.7. а) Барилгын ажил гүйцэтгэгч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар б) Барилга хариуцан бариулагчийг томилсон тухай гүйцэтгэгч байгууллагын даргын тушаал, инженерийн дипломын хуулбар	а) Барилгын ажил гүйцэтгэгч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар б) Барилга хариуцан бариулагчийг томилсон тухай гүйцэтгэгч байгууллагын даргын тушаал, инженерийн дипломын хуулбар;
1.8. Барилгын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө	Барилгын ажил гүйцэтгэх гэрээ, ажил гүйцэтгэх график, захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ, зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээ, хуваарь, талбай зохион байгуулалтын зураг;
<p><b>Тайлбар:</b> 1. Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд заасан хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.</p> <p>2. Барилгын тухай хуулийн 26.2. “Барилга байгууламжийн үндсэн бүтээцэд болон инженерийн шугам сүлжээний хэмжээ, хүчин чадалд өөрчлөлт оруулсан бол зураг төслийг дахин боловсруулж, барилгын ажлын зөвшөөрөл шинээр авна.” Гэж зааснаар дээрх материалыг дахин бүрдүүлж зөвшөөрлийг шинээр авна.</p> <p>3. “Барилгын тухай” хуулийн 30.2-т заасны дагуу хүсэлт гаргаагүй, барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа дууссан бол энэ хуулийн 27.2, 28.2-т заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийг шинээр авна.</p>	



ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

<b>ХОЁР. БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГУУЛАХ</b>	
<b>Баримт бичгийн нэр</b>	<b>Тайлбар</b>
2.1. Захиалагчийн хүсэлт	Захиалагчийн өргөдөл, албан бичиг /иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
2.2. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл	Урьд олгосон барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн эх хувь;
2.3. Зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрөл	Зураг төсөл зохиогч, барилгын ажлын гүйцэтгэгч /ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч/ байгууллагуудын улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
2.4. Барилга угсралтын ажил гүйцэтгэх төлөвлөгөө /график/	Барилгын дуусаагүй ажлыг гүйцэтгэх хугацааг тодорхой тусгасан төлөвлөгөө /эсвэл календарьчилсан график/ эх хувь;
<b>Тайлбар:</b>	
1. “Барилгын тухай” хуулийн 30.1-д заасан хугацаанд дуусаагүй бол захиалагч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтийг энэ хуулийн 27.1-д заасан байгууллагад гаргаж, дуусаагүй ажлыг гүйцэтгэх бодит хугацааг тусгасан төлөвлөгөөг хавсаргана. “Барилгын тухай” хуулийн 30.2-т заасны дагуу хүсэлт гаргаагүй, барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа дууссан бол энэ хуулийн 27.2, 28.2-т заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийг шинээр авна.	
2. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн 2.13-т “Захиалагч барилгын ажлын явцад дараах өөрчлөлт гарсан тохиолдолд Барилгын тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу зохих арга хэмжээг авч, зөвшөөрөл олгосон байгууллагад тухай бүрт нь мэдэгдэнэ” гэж заасны дагуу дараах тохиолдолд зөвшөөрлийг сунгуулна. Үүнд: дуусаагүй барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулах болон уг хугацаа дуусгавар болох үед.	



ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

<b>ГУРАВ. БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ</b>	
<b>Баримт бичгийн нэр</b>	<b>Тайлбар</b>
3.1. Барилгын ажлын зөвшөөрлийн нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлт	Захиалагчийн өргөдөл, албан бичиг /иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/;
3.2. Захиалагч, гүйцэтгэгч болон зураг зохиогч, хяналт гүйцэтгэх байгууллагатай шинээр байгуулсан гэрээ	Барилгын ажил гүйцэтгэх, болон зураг зохиогч байгууллагатай /зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан бол/ шинээр байгуулсан гэрээний эх хувь;
3.3. Барилгын ажил гүйцэтгэх болон зураг зохиогч, хяналт гүйцэтгэх үйлчилгээ эрхлэх байгууллагын тусгай зөвшөөрөл	Барилгын ажил гүйцэтгэгч, зураг зохиогч /зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан бол/-ийн тусгай зөвшөөрлийн хуулбар;
3.4. Захиалагч, гүйцэтгэгч болон зураг зохиогч, хяналт гүйцэтгэх байгууллагатай байгуулсан гэрээг цуцалсан тухай шийдвэр	Барилгын ажил гүйцэтгэх, болон зураг зохиогч /зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан бол/-той байгуулсан гэрээг цуцалсан тухай баримт бичгийн эх хувь;
3.5. Зураг төсөлд орсон томоохон өөрчлөлттэй холбоотой баримт бичиг	Барилгын зориулалт өөрчлөгдсөнөөр батлагдсан Архитектур төлөвлөлтийн даалгаварт өөрчлөлт оруулсан баримт бичгийн эх хувь. Жич: Барилгын үндсэн бүтээцэд өөрчлөлт ороогүй байх;
<b>Тайлбар:</b> Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн 2.13-т “Захиалагч барилгын ажлын явцад дараах өөрчлөлт гарсан тохиолдолд “Барилгын тухай” хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу зохих арга хэмжээг авч, зөвшөөрөл олгосон байгууллагад тухай бүрт нь мэдэгдэнэ” гэж заасны дагуу дараах өөрчлөлт орсон бол Барилгын ажлын зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулна. Үүнд: - Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд заасан мэдээлэлд өөрчлөлт орох; - Гүйцэтгэгч, захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллага өөрчлөгдөх; - Барилгын зориулалт өөрчлөгдсөнөөр батлагдсан Архитектур төлөвлөлтийн даалгаварт өөрчлөлт оруулсан;	



ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

<b>ДӨРӨВ. БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙГ БУУЛГАХ АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ АВАХ</b>	
<b>Баримт бичгийн нэр</b>	<b>Тайлбар</b>
4.1. Захиалагчийн хүсэлт	Захиалагчийн өргөдөл, албан бичиг /иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/
4.2. Барилга байгууламжийг буулгах шийдвэр	Барилгыг буулгах шийдвэрийн эх хувь
4.3. Гэнэтийн ослын болон хариуцлагын даатгалд даатгуулсан бол гэрчилгээг хавсаргах	Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Барилгын тухай хуулийн 8.3-т “Энэ хуулийн 44.3.2, 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.” гэж заасны дагуу мөн хуулийн 44.3.2, 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна. Мөн хуулийн 8.4.Барилгын ажлын гүйцэтгэгч тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна.
4.4. Гүйцэтгэгч байгууллагын тусгай зөвшөөрөл	Барилга, байгууламжийн ажил гүйцэтгэх ерөнхий ба туслан гүйцэтгэгч байгууллагуудын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байх/
4.5. Барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө	Барилгын захиалагч, гүйцэтгэгч, хамтран гаргасан төлөвлөгөө, талбай зохион байгуулалтын зураг. Барилга үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-04-06 “Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД20-101-12 –ийг мөрдлөг болгон боловсруулна. /зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан бол хавсаргана/